

**ТӨРИЙН БАНКНЫ ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН  
ДАНЗАНБАЛЖИРЫН ЭНХЖАРГАЛЫН  
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

**1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН**

Нэгдүгээр улиралд 7 хуралд оролцож 76 асуулт асууж, 36 санал дэвшүүлсэн:

1. Төрийн банкны ТУЗ-ийн зарлагдсан 4 хуралд 100 хувь оролцсон. Үүнд:

- 1 сарын 30-ны өдрийн хуралд 18 асуулт, 4 санал,
- 2 сарын 17-ны өдрийн хуралд 23 асуулт, 13 санал,
- 3 сарын 15-ны өдрийн хуралд 4 асуулт, 3 санал,
- 3 сарын 17-ны өдрийн хуралд 7 асуулт, 5 санал,

бүгд 52 асуулт тавьж, хариулт авсны дараа 25 санал гаргасан.

- Ногдол ашиг хуваарилахдаа банкны алс хэтийн бодлого, ялангуяа ирэх жилийн бизнес төлөвлөгөө болон ашгийн төлөвлөсөн түвшинтэй уялдуулан тогтвортой байх зарчмыг баримтлах санал гаргасан.
  - “Мэдээллийн аюулгүй байдлын бодлого”-ыг шинэчлэн батлах тухай журамд хариуцлагын асуудлыг нэмж тусгах санал гаргаж дэмжүүлсэн.
  - “Сонирхлын зөрчлийг зохицуулах журам” -ын төсөлд Сонирхлын зөрчлийг хянах журам гэж нэрлэх санал гаргаж шийдүүлсэн. Журамд АТГ-д гаргадаг тайлангийн мэдээллийг ашиглах боломжтой байхаар зохицуулан давхцал, үргүй зардал гаргахгүйгээр зохион байгуулах санал дэвшүүлж дэмжигдсэн.
  - “Грант торнтон аудит” ХХК-ийн презентаци танилцуулгад дурьдагдсан залруулгын гүйлгээнүүд хийгдсэн эсэхэд банкны удирдлага, Аудитын хорооноос асуулга тодруулга тавихад Санхүүгийн захирал Гантуяа зээлийн эрсдэлийн сангийн нөөц байгуулах 27,9 тэрбум төгрөгийн залруулгаас бусад нь хийгдсэн, аудитын Хороон дарга С. Цэнд-Аюуш энэ асуудлыг хороон дээр талууд хэлэлцэж нэгдсэн ойлголтонд хүрсэн гэж танилцуулсныг анхааралдаа авахыг хуралд санал болгоход Монголбанкны тогтоосон зээлийн ангиллын шалгуурыг Төрийн банкнаас мөрдөж байгаа, СТОУС 9-ыг хэрэглэх зөвлөмж Монголбанкнаас батлагдаж ирээгүйг мэдээлсэн.
  - Мэдээллийн Технологийн талаархи аудитын 100 илүү хуудастай тайлангийн орчуулга дуусаагүй тул гишүүдэд тараагдаж танилцуулагдаагүй ч аудитаар илэрсэн асуудлын эрсдэлийн үнэлгээ, зөвлөмжийг товч мэдээлсэн.
2. Нэр дэвшүүлэх хорооны Даргын хувьд 2 удаа хурал зохион байгуулан удирдлаа. Үүнд:
- 2 сарын 02-ны өдрийн хуралд 3 асуулт, 1 санал,
  - 2 сарын 14-ний өдрийн хуралд 9 асуулт, 5 санал,

бүгд 12 асуулт тавьж, хариулт авсны дараа 6 санал гаргасан.

- Нэр дэвшүүлэх хорооны 2023 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.
  - Хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах, хувьцаа эзэмшигчдээс банкны үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдлыг хүлээн авч санал, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий байнгын бус үйл ажиллагаатай Хяналтын зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.
  - Нэр дэвшүүлэх хорооны дүгнэлт саналыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.
  - Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журамд өөрчлөлт оруулах саналыг ТУЗ-ийн хуралд танилцуулж дэмжлэг авсан.
3. Эрсдэлийн удирдлагын хорооны 2 хурал зарлагдсанаас 1 сарын 30-ны өдрийн хуралд гадаадад ажилтай байсан тул оролцох боломжгүй байсан. 3 сарын 15-ны өдрийн хуралд 12 асуулт тавьж, хариулт авсны дараа 5 санал гаргасан.
- Эрсдэлийн удирдлагын газраас гаргасан санал зөвлөмж дүгнэлтийг бодит байдалд хэрэгжүүлээгүйгээс банканд эрсдэлт нөхцөл үүссэн тохиолдол бүрийг тухай бүр ЭУХ-нд шуурхай танилцуулж байх саналыг гаргаж хурлын тэмдэглэлд тусгуулж мөрдүүлж эхэлсэн.
  - Эрсдэлээс хүлээж болзошгүй алдагдлын хязгаарыг 2022 онд 8 хувиар тогтоож байсныг чангатган илүү консерватив түвшинд хүргэх саналыг дэмжсэн.
  - Үйл ажиллагааны тайланд дундаж давхаргад зориулсан зээл олголтын мэдээллийг бүтээгдхүүн тус бүрээр гаргахдаа мөнгөн дүнгээр, зээлдэгчдийн тоогоор гэх мэтчлэн хэрэглэгчдэд ойлгомжтой тодорхой хүртээмжтэй байдлаар гаргах, эрсдэлийн удирдлагын газрын хийсэн ажлыг нэмж тусгах саналуудыг гаргаж хурлын тэмдэглэлд тусгуулан үүрэгжүүлсэн.
4. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн Global Compact-д Төрийн банкыг нэгдэх нь зүйтэй саналыг гаргаж дэмжүүлсэн.
5. Монголбанкны Хяналт шалгалтын удирдлагуудтай хийсэн уулзалтанд оролцож, хараат бус гишүүний үүрэгт ажлынхаа талаар танилцуулсан. Монголбанкнаас хийж байгаа шалгалтын талаар асууж, чиглэл зөвлөмж авсан.

## **2023 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН**

1. Хувьцаа эзэмшигчдийн 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралд Хяналтын зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулалтын үр дүнгийн танилцуулга хийж, хувьцаа эзэмшигчдийн асуултанд хариулж оролцсон.
2. ТУЗ-ийн зарлагдсан 5 хуралд 100 хувь оролцсон. Үүнд:
  - 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуралд 1 санал,
  - 5 дугаар сарын 3-ны өдрийн хуралд 5 асуулт, 3 санал,
  - 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралд 1 санал,
  - 6 дугаар сарын 2-ны өдрийн хуралд 1 санал,
 бүгд 5 асуулт тавьж, хариулт авсны дараа 6 санал гаргасан.

3. Нэр дэвшүүлэх хорооны Даргын хувьд 5 сарын 17, 19-ний өдрүүдэд Цалин урамшууллын хороотой хамтарсан хурлыг удирдаж, Төрийн банк ХК-ийн Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх урамшуулал олгох журмын болон гэрээний төслүүдийг заалт тус бүрээр хэлэлцүүлж гишүүдээс гаргасан санал шүүмжлэлийн дагуу эцэслэн боловсруулсны дараа ТУЗ-д танилцуулсан. ТУЗ-ийн гишүүдийн 2023 оны тайланг Нэр дэвшүүлэх хороонд ирүүлж байхыг Засаглалын албанд үүрэг болгосон. Гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулахтай холбогдуулан Засаглалын алба, Дотоод албаны газрын ажилтнуудад Монголд хэрэгжүүлж байсан туршлага, олон улсын чиг хандлагын талаар зөвлөгөө зөвлөмж өгч 6 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журмын төслийг хэлэлцүүлэн, шинэчилсэн төслийг ТУЗ-д танилцуулсан.
4. Эрсдэлийн хорооны Гишүүний хувьд 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралд оролцон, Банкны эрсдэлийн удирдлагын чиглэлээр 2023 оны 1 дүгээр улиралд хийгдсэн ажлын тайлантай танилцаж эрсдэлийн талаар зөвлөмжийг сайжруулах, үр өгөөжтэй ажиллахыг анхааруулж тодорхой зөвлөмж өгсөн. Өрсөлдөгч банкуудын гаргаж байгаа шинэ бүтээгдхүүн үйлчилгээний нөхцөлүүд сайжирч байгаа зар мэдээллээс хоцорч, Төрийн банк шийдвэр гаргаж байгаа нь харилцагчаа, сайн зээлдэгчээ алдаж байгааг анхааруулж, цаашид цаг алдалгүй шийдвэр гаргаагүйгээс олох ёстой ашиг боломжоо алдаж байгаа эрсдэлүүдийг, өрсөлдөх чадварын эрсдэлийн үнэлгээг танилцуулахыг зөвлөсөн. 2023 оны 1 дүгээр улирлын Чанаргүй активын тайлантай танилцаж, зөвхөн урамшуулалт аян зарлаж байгаа үед муу чанаргүй зээл төлөгдөж байгаа, чанаргүй зээл бий болгосон хариуцлагын тогтолцоонд шүүмжлэлтэй хандаж, хураагдсан эд хөрөнгө, зээлийн барьцаа хөрөнгийг зарж борлуулах асуудлыг ил тод болгон ажиллахыг зөвлөсөн. Өрийн үлдэгдлийг гаргаж танилцуулахдаа хуримтлагдсан хүүг оруулан бүх өрийн түүхийг хамруулан танилцуулж байх, хөнгөлсөн, нөхцөл өөрчилсөн мэдээллийг иж бүрэн тусгах саналыг гаргасан. Алтай группийн зээл олголт, төлүүлэлтийн талаар хангалттай ажиллахгүй байгаа талаар асуулга тавьж, Дотоод аудитын газар хамгийн том муу зээлдэгчийн талаар шалгалт хийгээгүй байгааг анхааруулж, эрсдэлийн үнэлгээг шинэчлэн, бусад банк, сангуудаас авсан зээл зэрэгтэй холбоотой хууль хяналтын байгууллагуудын авч хэрэгжүүлж байгаа мэдээллийг тодруулж, танилцуулж байгаа материалыг илүү иж бүрэн болгож ТУЗ-ийн хуралд танилцуулахыг санал болгосон. Хорооноос өгсөн үүрэг даалгаврын биелэлттэй танилцаж илүү үр дүнд суурилсан танилцуулгыг бэлдэж байхыг шаардсан. Актив пассивын удирдлагын хорооны тайлантай танилцаж Пассивын удирдлага хангалтгүй, том хувьцаа эзэмшигчээр (Сангийн яам) дамжуулан гадаадаас хөрөнгө босгох талаар хангалтгүй ажиллаж байгааг шүүмжлэн, ялангуяа харилцагчаа алдахгүй байх стратеги техник технологи туршлагаас судалж, пассив хөрөнгийн удирдлагыг шинэчлэн нэвтрүүлэх шаардлагатай талаар санал өгсөн. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны 2023 оны ажлын төлөвлөгөөнд а) хугацааг хуульд заасан тайлан гаргах хугацаатай уялдуулан мөрдөх, б) эрсдэлийн шинэ техник, эрсдэлийн шинжилгээ, шинэ эрсдэлүүдийг улирдах арга технологиос Эрсдэлийн хорооны гишүүд, эрсдэлийн удирдлагын ажилтнууд суралцаж чадавхи нэмэгдүүлэх, в) Эрсдэлийн удирдлагын ажилтнуудтай жилд нэгээс доошгүй удаа Эрсдэлийн Хороо уулзалт хийдэг болох саналуудыг тусгуулсан.

5. Хөдөө орон нутаг дахь барилгын хөрөнгө оруулалтын явцыг сумдад томиллолтоор явж танилцсан тухай тайланг ТУЗ-д танилцуулж, банкны брэндинг, өрсөлдөх чадвар хөдөө орон нутагт ялангуяа суманд тун хангалтгүй байгааг бодит харьцуулсан зургаар мэдээлж, үйлчилгээний ажилтнуудын нэгдсэн ажлын дүрэмт хувцсыг олгохоо зогсоосон, сумдад түрээсэлж байгаа байрууд стандарт хангахгүй, үйлчилгээний шүүгээ ширээ тэтгэврийн хүмүүс үйлчлүүлэхэд ээлгүй хэт өндөр, сандал ширээ хуучирч эвдэрсэн байгааг анхаарах, хөдөөгийн барилгуудын талаар нэгдсэн үнэлгээ дүгнэлт, бодлоготой болох, сумдын барилгыг төсөвлөхдөө хэт үндэслэлгүй танаж хасдгаас гүйцэтгэгч барилгаа дутуу барьж орхидог хандлага газар авсныг анхаарах, төсвийг үндэслэлгүй хасснаас барилга саатсан тохиолдлуудыг ДАГ шалгаж танилцуулах шаардлагатайг, Сангийн яамны төлөөлөл ТУЗ-ийн гишүүдээс Төрийн хэмнэлтийн хуулийн зарим заалт үйлчилгээний өрсөлдөх чадварт чөдөр тушаа болж байгаа эсэх талаар асууж лавлан, цаашид ТУЗ банкны брэндингийн талаархи бодлого, мэдээлэлтэй нэн яаралтай танилцан, үнэлгээ өгөх, өрсөлдөх чадварын хэтийн төлөв, алсын хараатай байлгахын тулд Гүйцэтгэх удирдлагад үүрэг өгүүлэх талаар шийдвэр гаргаж өгөхийг хүсч, шийдүүлсэн.
6. Говь-Алтай аймгийн Эрдэнэ суманд зохиогдсон малчдын чуулганд санхүүгийн боловсролын лекц орж, малчдыг зардлын хэмнэлт гаргах замаар хуримтлалтай болгох дадлага эзэмшүүлэх сургалтыг хийсэн нь тэднийг зээлээс хэт хамааралтай байдлаас гаргахад чиглэгдсэн.
7. Монголын эдийн засгийн форумд оролцож хөрөнгө оруулагч нарт банкны ирээдүйн хандлага чиглэлийн талаар танилцуулсан.

Хурал тус бүрт оролцсон тухай дэлгэрэнгүй тайланг Монголбанканд тухай бүр гаргаж өгсөн бөгөөд хурлын товч мэдээллийг хурал тус бүрээр ТУЗ-ийн хурлын протоколоос НБД-аар гаргуулж, хавсралтаар хүргүүлж байсан.

Тайланг гаргасан



Д. ЭНХЖАРГАЛ